

ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын нэр: **Цахилгаан хамгаалах хэрэгсэл нийлүүлэх
гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах**

Тендер шалгаруулалтын дугаар: **ХА №20/12**

Хаяг: Улаанбаатар хот Багануур дүүрэг
үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦТС”
ТӨХК-ийн конторын байр.

Утас: 99020551

Факс: 70210167

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“БЗӨБЦТС” ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос **ХА №20/12 дугаартай Цахилгаан хамгаалах хэрэгсэл нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.**

Үнийн санал ирүүлэх барааны тоо хэмжээ, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 16 цаг 00 минутаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим хаягаар ирүүлнэ.

Үнийн саналын нээлтийг 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 16 цаг 30 минутанд цахим хаягаар нээнэ.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Утас: 99020551

Факс: 70210167

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, цахим системээр нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон ийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Техникийн тодорхойлолт.
 - (г) Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материал. /ТШӨХ-ийн ТООЗ 1.1-д заасны дагуу/
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**



ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар ирүүлнэ. 2. Үнийн саналыг маягтын дагуу ирүүлнэ. 3. НӨАТ төлөгчийн гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ. /НӨАТ төлөгч биш бол энэ тухай албан бичиг ирүүлнэ/. 4. 2019 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг дүгнэлтийн хамт ирүүлэх 5. Сүүлийн 2 жил /2018,2019/-ийн борлуулалтын дундаж орлого нь тендерийн төсөвт өртгөөс багагүй байна. /Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 225 дугаар тушаалын хавсралт “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээллэх журмын 3.7 дахь заалтын дагуу цахим системийн лавлагааг үндэслэнэ/. 6. Нийлүүлэх бараа материалын техникийн тодорхойлолт ирүүлнэ. /Захиалагчийн техникийн тодорхойлолтын шаардлагыг хангасаныг нотлох санал болгож буй бараа материалын брэнд, тип марк зэргийг тусган харьцуулсан тодорхойлолтыг ирүүлнэ/ 7. Тухайн аж ахуйн нэгж шүүхийн ямар нэгэн маргаанд хариуцагчаар оролцож байгаагүй тухай шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт. 8. ШШГЕГ-ын шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт. /Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр төлбөргүй байх/ 9. Тендер нээсэн өдрийн байдлаар татварын өргүй байх. /Татварын тодорхойлолтыг www.tender.gov.mn цахим сайтын лавлагааг үндэслэнэ/ 10. Гэрээний тусгай нөхцлийн 4-р заалтыг хүлээн зөвшөөрсөн албан бичиг ирүүлнэ. 11. Баталгаат засварын хугацааг хүлээн зөвшөөрсөн албан бичиг ирүүлнэ. 12. Бараа материал нийлүүлэх хугацаа хуанлийн 21 хоногоос ихгүй байна. 13. Сүүлийн 2 жилийн /2018, 2019/ хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалт, гэрээ, гэрээ дүгнэсэн актыг ирүүлнэ. 14. 2018, 2019 онуудад гэрээгээр гүйцэтгэсэн ижил төстэй аль нэг ажлын гэрээний үүргээ бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон захиалагчийн тодорхойлолт ирүүлнэ. /Захиалагчийн тодорхойлолт ирүүлээгүй тохиолдолд гэрээний үүргээ хангалтгүй биелүүлж байсан гэж үзэн уг тендерээс татгалзана/. 15. Тендерт ирүүлсэн файл нь тод гаргацтай байх ба бүрэг уншигдахааргүй байвал тус файлыг ирүүлээгүйд тооцож тендерээс татгалзах үндэслэл болно. <i>Дээрх баримт бичгийг бүрдүүлж ирээгүй тохиолдолд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3 дахь заалтын шаардлагыг хангаагүй гэж үзэн ирүүлсэн тендерээс татгалзана.</i>
ТӨӨЗ 2.1	Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа: Тендерийн баримт бичгийг www.tender.gov.mn цахим хаягаар авна. 2020 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн 16 цаг 00 минут.
ТӨӨЗ 2.2	Тендерийн нээлт хийх хугацаа: Тендерийн нээлтийг www.tender.gov.mn цахим хаягаар нээнэ. 2020 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн 16 цаг 30 минутад
ТӨӨЗ 2.3	Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлалгүй ирүүлнэ. Шаардлагагүй
ТӨӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй

Гурав. БАРАА МАТЕРИАЛЫН ТОО ХЭМЖЭЭ, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ



№	Материалын нэр	Техникийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Нүдний хамгаалах шил	<p>1. Стандарт MNS5389:2004 нийцсэн байна.</p> <p>2. Нүдний шил нь хөдөлмөрийн нөхцөлөөс шалтгаалан бууралтгүй, тунгалаг</p> <p>3. Нүдний шил нь өнгө үзэмжтэй, хөнгөн, арьсанд харшил өгөхгүй PVC полиамид, полиэтилен материалаар хийсэн байна</p> <p>4. Нүдний шил нь хэрэглэхэд хялбар, эвдэрсэн эд ангийг сольж засварлах бүрэн боломжтой байна. Нүдэнд орж болзошгүй механик биет болон хурц гэрлээс хамгаалах онцлогоос хамааруулан шилний зузаан 1мм-ээс 4мм хүртэл байна.</p> <p>5. Ажиллах орчноос шалтгаалан нүдний шилийг дуулганд угсарч, хэрэглэнэ. Техникийн үзүүлэлт, бүтэц салхины хүчийг тэсвэрлэх чадвараар нь: Сайжруулсан ---- S /12м/с/ Зориулалтаар нь: Гадны биет – 4, Хий болон тоос, шороо – 5, Цахилгаан нум – 8</p>	ш	130 /цагаан /
			ш	8 /хар/
2	Дуулга /КАСКА/	<p>MNS 5621-2006 ISO,EN397, ISO EN50365 стандартын шаардлагыг хангасан байна.</p> <p>Үүнд:</p> <p>1. Механик үйлчлэлээс хамгаалах чадвар: 5 кг-ийн хагас бөмбөрцөг хэлбэртэй ачааг 1 м өндрөөс унагаж туршсан байна.</p> <p>2.Цахилгаан гүйдлээс хамгаалах чадвар 1000В хүртэл</p> <p>3.Температурын горим: -30⁰С-:+50⁰С</p> <p>4.Дуулгын их бие:полиэтилен PE болон поликарбонат PC материалаар хийгдсэн байна.</p> <p>5.Толгойн оройноос хөндийрүүлэх татуурга: 3ш байх ба дуулганд 6 цэгээр холбогдоно.</p> <p>6.Дуулганы бүч нь чихний 2 талаар орж эрүүвчлэгддэг байна.</p> <p>7.Хөлс шингээгчтэй байна.</p> <p>8.Толгойд бэхлэгдэх хэсэг нь хэмжээг тохируулах тохируулгатай байна.</p>	ш	95


		9.Каскны ар болон хажуу талаас харагдахаар гэрэл ойлгогчтой байна. (тус бүрдээ 55мм эсвэл 5 см дөрвөлжин буюу туузан)												
3	Цахилгаан нумнаас хамгаалах нүүрэвч	<p>ISO EN166 стандартын шаардлагыг хангасан байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Нүүрэвчний харааны зэрэг: 1 буюу хараанд өөрчлөлт өгөхгүй байх 2. Зурагдах, зүсэгдэхээс хамгаалагдсан байна. 3. Линзний зузаан 1,2мм-ээс багагүй байна. 4. Нүүрэвчний материал: поликарбонатаар хийгдсэн байна. 5. Нүүрэвчний өндөр нь 240мм-ээс багагүй байна. 6. Дуулганд бэхлэх боломжтой, дуулганд бэхлэгдэхдээ нумарсан байдлаар бэхлэгдэнэ. 7. Ультра ягаан туяаны шүүлтүүртэй /3/ гэрэл шүүх чадвар-1,2 химийн бодис /3/ болон цахилгаан нумнаас хамгаалсан /8/35кВ хүртэл 8. Металл хийц ороогүй 	ш	33										
4	Резинэн бот	<ol style="list-style-type: none"> 1. Ботын нийт өндөр нь 160 мм-с багагүй байх ёстой. 2. Бот нь уян хатан чанар, тохиромжтой эргономик хэлбэртэй, гутлын гадуур өмсөхөд тохирсон байх. 3. Ботын диэлектрик шинж чанар нь 20 кВ-ын хүчдэл, нэвчилтийн гүйдэл нь 10 мА-аас багагүй байх ёстой. 4. Бот нь -30⁰С-аас +50⁰С хэм хүртэл температурт өөрийн шинж чанарыг бүрэн хадгалдаг байх. 5. Өнгө - шаргал эсвэл цайвар шаргал байх. 6. Ботны ул нь 6 мм зузаантай байх 7. Гутал болон ботны хэмжээ п / а <table style="margin-left: 40px;"> <tr><td>42</td><td>315</td></tr> <tr><td>43</td><td>322</td></tr> <tr><td>44</td><td>330</td></tr> <tr><td>45</td><td>337</td></tr> <tr><td>46</td><td>345</td></tr> </table>	42	315	43	322	44	330	45	337	46	345	хос	8
42	315													
43	322													
44	330													
45	337													
46	345													










5	Резинэн бээлий /1кВ хүртэл болон түүнээс дээш хүчдэлд/	<ol style="list-style-type: none"> 1. Резинэн бээлий нь орчны -40-аас + 40 хэм хүртэл харьцангуй чийгшил, 75% хүртэл уян хатан чанараа алддаггүй байх 2. Бээлийний диэлектрик шинж чанар нь 6 кВ-ын хүчдэл, нэвчилтийн гүйдэл нь 7 мА-аас багагүй байх ёстой. 3. Бээлийний нийт урт 350 мм-с багагүй байх ёстой. 4. Диэлектрик бээлий дотор даавуун буюу сүлжмэл бээлий давхарлан өмсөх боломжтой байх ёстой. 	хос	12
6	Хөндийрүүлэх дэвсгэр	<ol style="list-style-type: none"> 1. Дэвсгэр нь -15°C, $+50^{\circ}\text{C}$ хэм хүртэл температурт өөрийн шинж чанарыг бүрэн хадгалдаг байх, 2. 50Гц, 20кВ хүчдэл тэсвэрлэх, нэвчилт 160МА/м, цахилгааны орны нөлөөлөл 10кВ/мм, 3. Дэвсгэрийн зузаан нь 6мм+-1мм байх. 4. Хэмжээ 1х1.2м харьцаатай байх. 5. Дэвсгэр нь хальтирч гулгахааргүй гадаргуутай байх ёстой. 	ш	28
		1.АШ буюу цахилгаан байгууламжийн тоноглолд хүрч холбоос үүсгэх хавчаар нь металл хийцтэй, найрлага нь гангаар		



7	Зөөврийн газардуулга /1000В-оос дээш/	<p>хийгдсэн, нунтаг паалангаар хучсан, зэврэлтэнд тэсвэртэй материалаар хийгдсэн байна. Бариул хэсэг нь цахилгаан гүйдэл дамжуулахгүй тусгаарлах материал /бакелит, пластмас, мод, тос шингээсэн тусгаарлагч, эпоксит лакан бүрхүүлтэй/ -аар хийгдсэн, барих гадаргуу /гар хүрч харьцах/ нь гар гулгахгүй хэлбэр бүхий хөндийрүүлэх резин материалтай, 1100мм-ээс багагүй урттай. Их бие дээрээ газардуулгын утас бэхлэгчтэй.</p> <p>2.Газардуулгын дамжуулагч утас 25мм²-аас багагүй хөндлөн огтлолтой, 12 м-ээс багагүй урттай, уян зэс утас. Уян зэс утасны гадна тусгаарлага бүрхүүл нь тунгалаг полимер, чийгэнд тэсвэртэй, уян хатан чанартай, үрэлтэнд тэсвэртэй, хүйтэнд хөшүүн болохгүй хөлдөж хагарахгүй шинж чанартай.</p> <p>3.Газардуулгын гадсанд бэхлэх хавчаар нь /гадсанд хүрч холбоос үүсгэх/ металл хийцтэй, найрлага нь гангаар хийгдсэн, нунтаг паалангаар хучсан, зэврэлтэнд тэсвэртэй, хавчилтыг тохируулах чангалагчтай, их бие дээрээ газардуулгын утас бэхлэгчтэй..</p> <p>4. Газардуулгын гадас хатуу металл хийцтэй, зэвэрдэггүй материалын орцтой, цохилт шингээх толгой хэсэгтэй, хөрсөнд орох шовх үзүүртэй, 20мм²-аас багагүй диаметртэй, 1м-ээс багагүй урттай.</p> <p>5.Ажиллах температурын горим: -45⁰С:-+45⁰С</p> <p>6.Зөөврийн газардуулгыг задалж салган овор хэмжээг багасгах боломжтой, уут савтай байна.</p> <p>7.35кВ хүртэл хүчдэлтэй, 50Гц давтамжтай тоноглолд хүрч ажиллахад хүний аюулгүй байдлыг хангах</p>	КОМ	4
		<p>1.Хүчдэл заагуурын урт /сунгасан үед/ 0.8м-ээс ихгүй, тээврийн байрлалд /эвхсэн үед/ 0.42м-ээс ихгүй</p> <p>2. Тусгаарлах хэсэг /ажлын хэсгээс бариул хүртэлх/ цахилгаан гүйдэл дамжуулахгүй тусгаарлах материал /бакелит, пластмас, мод, тос шингээсэн тусгаарлагч/ -аар</p>		

8	 <p>0.1-10kV 袖珍微型伸缩式验电器</p> <p>Нэг туйлт хүчдэл заагуур /10,6кВ/</p>  <p>0.1-10kV 袖珍伸缩式声光高压验电器</p>	<p>хийгдсэн, тусгаарлах хэсгийн урт 0.24м –ээс багагүй</p> <p>3.Бариулын хэсэг /гар хүрч харьцах/ тусгаарлах материалтай, гар гулгахгүй хэлбэр бүхий хөндийрүүлэх резин гадаргуутай, бариулын хэсгийн урт 0.12м-ээс багагүй.</p> <p>4.Температурын горим: -40⁰С-:+40⁰С</p> <p>5.6-:-10кВ хүчдэлтэй, 50Гц давтамжтай тоноглолд хүрч ажиллахад хүний аюулгүй байдлыг хангаж, дуут гэрлэн дохио өгнө</p> <p>6.Дуут гэрлэн дохиог ажиллуулах дотоод /батарей/ тэжээлтэй</p> <p>7.Хүчдлийн доод мэдрэмж нь 1.3кВ-оос ихгүй</p> <p>7. Тээврийн байршилд цахилгааны хэлхээний ажлын хэсэг, тусгаарлах хэсэг эвхэгдэн нягтарч механик эвдрэлээс хамгаалагдах, уут савтай байх.</p> <p>7.40кВ-оос багагүй туршилтын хүчдлийг даах</p> <p>8.Жин 0.42кг-аас ихгүй</p>	ш	9
9	<p>Нэг туйлт хүчдэл заагуур /35кВ/</p>	<p>1.Хүчдэл заагуурын урт /сунгасан үед/ 0.88м-ээс ихгүй, тээврийн байрлалд /эвхсэн үед/ 0.44м-ээс ихгүй</p> <p>2. Тусгаарлах хэсэг /ажлын хэсгээс бариул хүртэлх/ цахилгаан гүйдэл дамжуулахгүй тусгаарлах материал /бакелит, пластмас, мод, тос шингээсэн тусгаарлагч/ -аар хийгдсэн, тусгаарлах хэсгийн урт 0.6м –ээс багагүй</p> <p>3.Бариулын хэсэг /гар хүрч харьцах/ тусгаарлах материалтай, гар гулгахгүй хэлбэр бүхий хөндийрүүлэх резин гадаргуутай, бариулын хэсгийн урт 0.12м-ээс багагүй.</p> <p>4.Температурын горим: -40⁰С-:+40⁰С</p> <p>5.10-:-35кВ хүчдэлтэй, 50Гц давтамжтай тоноглолд хүрч ажиллахад хүний аюулгүй байдлыг хангаж, дуут гэрлэн дохио өгнө</p> <p>6.Дуут дохио, гэрлэн дохиог ажиллуулах дотоод /батарей/ тэжээлтэй</p> <p>7.Хүчдлийн доод мэдрэмж нь 2.5кВ-оос ихгүй</p> <p>7. Тээврийн байршилд цахилгааны хэлхээний ажлын хэсэг, тусгаарлах хэсэг эвхэгдэн нягтарч механик эвдрэлээс хамгаалагдах, уут савтай байх.</p>	ш	11

		<p>7. Шугамын хүчдлээс 3 дахин их, гэхдээ 40кВ-оос багагүй туршилтын хүчдлийг даах</p> <p>8.Жин 0.7кг-аас ихгүй</p>		
10	<p>Зөөврийн хаалт, хашилт</p>	<p>Материал: Нэг маягийн цахилгаан тусгаарлах материалыг ашиглан хийсэн байна.</p> <p>Хийц: Зөөврийн зориулалттай, эвхэгддэг. Хаалт хашилтны өндөр нь 1,2м-ээс багагүй, өргөн нь 1,5м-ээс багагүй.</p> 	ш	16
	<p>Олс, татлага</p>	<p>Материал: Мяндсан олс.</p> <p>Хийц: Эрчилсэн 2 төрлийн олс байх. Урт нь 35м. Хөндлөн огтлол нь 15 ба 20мм-ээс багагүй. Бат бөх, зөөврийн зориулалттай.</p>	боодол	13


11		 		
12	<p>Хаалт хашилтны цацруулагчт ай тууз</p>	<p>Материал: Өнгөт цацруулагчтай болон анхааруулах бичлэг бүхий тууз Хийц: Полиэстер-90%, PVC-10% Хэмжээ: Шар өнгөтэй буюу CAUTION /АНХААР/ тууз нь 8,5см х 200м Улаан өнгөтэй буюу DANGER /АЮУЛТАЙ/ тууз нь 10см х 200м</p>  	<p>боодол</p>	<p>36</p>





<p>13</p>	<p>Замын босоо хаалт, цацруулагчтай</p>	<p>Материал: Хуванцар материалаар хийгдсэн. Улаан, хар өнгөтэй байж болно.</p> <p>Хийц: Конус хэлбэрийн шовгор хаалт, гинж болон оройгоос бүрдэнэ.</p> <p>Хэмжээ: Конус хэлбэрийн шовгор хаалтны өндөр нь 70 см, доод ёроолын өргөн нь 31 см.</p> <p>1.Шовгор конус хэлбэрийн хаалт</p>  <p>2. Шовгор конус хэлбэрийн хаалтны орой</p>  <p>3. Шовгор конус хэлбэрийн хаалтыг холбох гинж</p> 	<p>Ш</p>	<p>4</p>
-----------	---	---	----------	----------





14	 <p>Монтёрын хамгаалалтын бүс</p> 	<p>1.Монтёрын хамгаалалтын бүс нь ISO9001:2008 стандартыг хангасан, бүсэлхийний үндсэн бүс, нуруувч, бэхэлгээний бүслүүр, багажны уут гэсэн дөрвөн бүрдэлтэй байна.</p> <p>2.Бүсэлхийний үндсэн бүс нь 4.2мм-ээс багагүй зузаантай, 42мм-ээс багагүй өргөнтэй, 140мм-ээс багагүй урттай хөврөхгүй давхарласан сүлжмэл полипропилен материалтай, суналтын бат бэх 19кН-оос дээш, ам дарах нугалаа, гогцоог туузан элементийг оёх зориулалттай даацын утсаар оёсон, тээглүүрээр бүсийг 65-:-135мм хүртэл богиносгох уртасгах боломжтой. Тээглүүр нь авоматаар түгжигдэх /өөрөө сулрах буюу тайлагдах боломжгүй/, гараар тайлагдах хоригтой, хайлшан ган материалтай /гадуураа хөндийрүүлгэн бүрээстэй байж болно/. Бэхэлгээний бүслүүрийг тогтоох бүс нь үндсэн бүстэй давхарласан хийцтэй, үндсэн бүс тасарсан үед тогтоох бүс нь бэхэлгээний бүслүүрийн хамт хүнийг тогтоон үлдээх боломжтойгоор хийгдсэн, гогцоог бэхлэх гархинууд нь хайлшан ган материалтай /гадуураа хөндийрүүлгийн бүрээстэй байж болно/.</p> <p>3.Бэхэлгээний бүслүүр нь 4.2мм-ээс багагүй зузаантай, 42мм-ээс багагүй өргөнтэй, 180мм-ээс багагүй урттай хөврөхгүй давхарласан сүлжмэл полипропилен материалтай /сүлжмэл утсаар давхарлан сүлжсэн олсон материалтай байж болно/, суналтын бат бэх 19кН-оос дээш , ам дарах нугалаа, гогцоог туузан элементийг оёх зориулалттай даацын утсаар оёсон, тохируулгын гархиар бэхэлгээний бүслүүрийг 85-:-165мм хүртэл богиносгох уртасгах боломжтой. Тохируулгын гархи нь хайлшан ган материалтай, гадуураа хөндийрүүлгийн бүрээстэй. Бэхэлгээний бүслүүрийн тээглүүр нь автоматаар түгжигдэх гогцоотой, гараар тайлагдах хоригтой, хайлшан ган материалтай.</p> <p>4.Нуруувч нь 80мм-ээс багагүй өргөн, 550мм-ээс багагүй урттай, нурууг бүсний холголтоос хамгаалах нягтруулсан зөөлөвчтэй, үндсэн бүсэнд бэхлэгдэх 4-өөс доошгүй гогцоо бүхий загвартай. туузан</p>	ш	20
----	--	--	---	----


		<p>элементийг оёх зориулалттай даацын утсаар оёсон байна.</p> <p>5.Багажны уут нь бүсэлхийний үндсэн бүсэнд зүүх хийцтэй, 170x140мм-ээс /өндөр, өргөн/ багагүй харьцаатай, задгай амтай, даавуун /синтетик байж болно/ материалтай.</p> <p>6.Гадна ажилд хэрэглэх температурын горим -45°C-: $+45^{\circ}\text{C}$.</p> <p>7.Өндрийн хамгаалалтын бүсийг 225 кг ачаагаар 5 минут туршихад гажилтанд / бүсэлхийний үндсэн бүс, бэхэлгээний бүслүүр сунахгүй, хэгзрэлт өгөхгүй, бүс болон оёдлын утас тасрахгүй, тээглүүр, гархи эвдрэхгүй/ орохгүй.</p> <p>8.Жин 1.2 кг-аас ихгүй.</p>		
15	Хөндийрүүлэх штанг /35кВ/	<p>1.Ажлын хэсэг /тоноглолд хүрч үйлдэл хийх/ металл хийцтэй, ажлын хэсгийн урт 0.12м-ээс багагүй</p> <p>2. Тусгаарлах хэсэг /ажлын хэсгээс бариул хүртэлх/ цахилгаан гүйдэл дамжуулахгүй тусгаарлах материал /бакелит, пластмас, мод, тос шингээсэн тусгаарлагч, эпоксит лакан бүрхүүлтэй/ -аар хийгдсэн, тусгаарлах хэсгийн урт 1.2м –ээс багагүй</p> <p>3.Бариулын хэсэг /гар хүрч харьцах/ тусгаарлах материалтай, гар гулгахгүй хэлбэр бүхий хөндийрүүлэх резин гадаргуутай, бариулын хэсгийн урт 0.4м-ээс багагүй.</p> <p>4.Температурын горим: -40°C-: $+40^{\circ}\text{C}$</p> <p>5.Хөндийрүүлэх штанг задалж салган овор хэмжээг багасгах боломжтой, уут савтай байна.</p> <p>6.35кВ хүчдэлтэй, 50Гц давтамжтай тоноглолд хүрч ажиллахад хүний аюулгүй байдлыг хангах</p> <p>7.Шугамын хүчдлээс 3 дахин их, гэхдээ 40кВ-оос багагүй туршилтын хүчдлийг даах</p> <p>8.Жин 1.0кг-аас ихгүй</p>	ш	3
		<p>1.Ажлын хэсэг /тоноглолд хүрч үйлдэл хийх/ металл хийцтэй, ажлын хэсгийн урт 0.12м-ээс багагүй</p> <p>2. Тусгаарлах хэсэг /ажлын хэсгээс бариул хүртэлх/ цахилгаан гүйдэл дамжуулахгүй тусгаарлах материал /бакелит, пластмас, мод, тос шингээсэн тусгаарлагч, эпоксит лакан бүрхүүлтэй/ -аар хийгдсэн, тусгаарлах</p>		

16	Хөндийрүүлэх штанг /10,6кВ/	<p>хэсгийн урт 0.8м –ээс багагүй</p> <p>3.Бариулын хэсэг /гар хүрч харьцах/ тусгаарлах материалтай, гар гулгахгүй хэлбэр бүхий хөндийрүүлэх резин гадаргуутай, бариулын хэсгийн урт 0.4м-ээс багагүй.</p> <p>4.Температурын горим: -40⁰С-:+40⁰С</p> <p>5.Хөндийрүүлэх штанг задалж салган овор хэмжээг багасгах боломжтой, уут савтай байна.</p> <p>6.10кВ хүчдэлтэй, 50Гц давтамжтай тоноглолд хүрч ажиллахад хүний аюулгүй байдлыг хангах</p> <p>7.40кВ-оос багагүй туршилтын хүчдлийг даах</p> <p>8.Жин 0.8кг-аас ихгүй</p>	ш	3
17	Гагнуурын электрод баригч	<p>Гарт барихад эвтэйхэн, гулгамтгай биш байх</p> <p>Хүрэхэд хэцүү хэсгүүдэд гагнуур хийхэд электродыг гулзайлгахгүйн тулд 90⁰ ба 115⁰ гэсэн барилтын өнцөгтэй байх</p> <p>Электрод барих хэсэг нь латунь материалаар хийгдсэн байх</p> <p>Гүйдэл дамжуулах хэсгүүд нь дулаанд тэсвэртэй материалаар хийгдсэн байх</p> <p>Хавчигч пүрш нь найдвартай хамгаалагдсан байх</p> <p>Механик үйлчлэлд тэсвэртэй байх /унагах, цохилт зэрэг/</p> <p>Жин гагнуурын гүйдлээс хамааран 0,35-:-0,75кг байна</p>	ш	3
18	Гагнуурын баг	<p>Нүүр, нүдийг хамгаалах механик үйлчлэлд тэсвэртэй чанартай пластик материалаар хийгдсэн байна.</p> <p>Размерийг тааруулдаг өмсгөвчтэй байна</p> <p>Өнгө хувиргагч шилтэй, 5 үндсэн өнгө тохируулгатай, гагнуурын оч гэрлээс хамгаалах зориулалттай</p>	ш	3
19	Хөндийрүүлэх бахь /10, 6кВ/	<p>ОХУ-д үйлдвэрлэсэнтэй дүйцэхүйц чанартай, цахилгаан гүйдэл тусгаарлагч материалаар хийгдсэн, 2-10кВ хүчдэлд зориулагдсан, ажлын хэсэг нь ангайдаг байх, хөндийрүүлэгч хэсгийн урт 380 мм, бариул нь 130 мм урттай байна. MNS4660:98</p>	ш	2
20	Хөндийрүүлэх бахь /35кВ/	<p>ОХУ-д үйлдвэрлэсэнтэй дүйцэхүйц чанартай, цахилгаан гүйдэл тусгаарлагч материалаар хийгдсэн, 35кВ хүчдэлд зориулагдсан, ажлын хэсэг нь ангайдаг байх, хөндийрүүлэгч хэсгийн урт 750 мм, бариул нь 250 мм урттай байна. MNS4660:98</p>	ш	5

21	Зөөврийн газардуулга /1000В хүртэл/	Газардуулах утасны урт 9м-ээс багагүй, олон судалтай нүцгэн зэс утсаар хийгдсэн, хөндлөн огтлол нь 16мм ² , хөндийрүүлэгч хэсгийн урт 100 мм, бариул нь 120 мм байна. Төмөр гадасны урт 70 см, диаметр - 13мм ² . 1000В ба түүнээс доош хүртэл хүчдэлийн цахилгаан байгууламж, АШ-д ашиглах	ком	2
22	Хөндийрүүлэх бариултай монтёрын багаж	Багаж нь нүүрстөрөгчийн өндөр агууламжтай хатаасан гангаар хийсэн байна. Бариул хэсэг нь цахилгаан гүйдэл дамжуулдаггүй, халалт, чийг, техникийн тосны үйлчилгээнд тэсвэртэй, хүйтэнд хөлддөггүй зориулалтын материалаар хийгдсэн байна. Хөндийрүүлэх бариулын урт 100 мм-с багагүй байна.	ком	3
23	Аюулгүйн санамж	АТП, КТПН,ТП-ны 0.4кВ щитний хаалганы дотор талд нааж тогтоох А4 ба А3 хэмжээтэй аюулгүй ажиллагааны санамж бичиг	ш	40
24	Анхааруулах плакат 	Дэвсгэрийн хэмжээ 280x210 мм, цагаан өнгөтэй, гадна хүрээ 5 мм өргөн, хар өнгөтэй, дээд талын 2/3-т 10 мм хар хүрээтэй, шар дэвсгэртэй адил талт гурвалжин дотор хар өнгийн сум байна. Доод хэсэгт “Өндөр хүчдэл! Аюултай” гэж цагаан дэвсгэр дээр хараар бичнэ. Хуваарилах байгууламж, дэд станцын хаалганы болон хашааны гадна талд байнга байлгахгаар хадаж бэхлэнэ.	ш	370
25	Анхааруулах плакат 	Дэвсгэрийн хэмжээ 230x160 мм, цагаан өнгөтэй, гадна хүрээ 5 мм өргөн, хар өнгөтэй, дээд талын 2/3-т 10 мм хар хүрээтэй, шар дэвсгэртэй адил талт гурвалжин дотор хар өнгийн сум байна. Доод хэсэгт “Зогс! Өндөр хүчдэл” гэж цагаан дэвсгэр дээр хараар бичнэ. Ажлын байртай зэрэгцээ буюу эсрэг харсан ХХБ-ын хаалт, хүн явах зам, зөөврийн хаалт самбар, хөл хорьсон газруудад тавьсан түр хаалт, ИХБ-д болон ажлын байрны эргэн тойронд орших гүйдэл дамжуулах хэсгүүдийг хаасан бүх төрлийн хаалт хашилт дээр тавих зөөврийн тэмдэг юм.	ш	20
26	Анхааруулах плакат	Дэвсгэрийн хэмжээ 230x160 мм, цагаан өнгөтэй, гадна хүрээ 5 мм өргөн, хар өнгөтэй, дээд талын 2/3-т 10 мм хар хүрээтэй, шар дэвсгэртэй адил талт гурвалжин дотор хар өнгийн сум байна. Доод хэсэгт “Бүү авир! Аюултай” гэж цагаан дэвсгэр дээр хараар бичнэ.	ш	35

		Ажилтныг өргөхөд зориулсан механизм болон өндөрт байрлалтай ажлын байрны зэргэлдээ оршиж байгаа хийц хэсгүүд нэг бүр дээр нүдэнд харагдахуйц тавьж хэрэглэх зөөврийн тэмдэг юм.		
27	<p>Анхааруулах плакат</p> 	<p>Дэвсгэрийн хэмжээ 390x280 мм, цагаан өнгөтэй, гадна хүрээ 5 мм өргөн, хар өнгөтэй, дээд талын 2/3-т 10 мм хар хүрээтэй, шар дэвсгэртэй адил талт гурвалжин дотор хохимой толгойн зургийг хараар, сумыг улаанаар зурсан байна. Доод хэсэгт “Бүү авир! Үхэл” гэж цагаан дэвсгэр дээр хараар бичнэ.</p> <p>1000В-оос дээш хүчдлийн ЦДАШ-ын тулгуурт газраас 2,5-3 метрийн өндөрт байрлуулах байнгын плакат юм. Төв, суурин газарт тулгуур бүрт байрлуулах ба төв, суурин газрын гадна нэг тулгуур алгасаж байрлуулна. Төмөр ба модон тулгуур дээр хадаж, төмөр бетон тулгуур дээр барлаж болно.</p>	ш	240
28	<p>Анхааруулах плакат</p> 	<p>Дэвсгэрийн хэмжээ 200x160 мм, цагаан өнгөтэй, гадна хүрээ 5 мм өргөн, хар өнгөтэй, дээд талын 2/3-т 10 мм хар хүрээтэй, шар дэвсгэртэй адил талт гурвалжин дотор хар өнгийн сум байна. Доод хэсэгт ““Бүү хүр! Аюултай” гэж цагаан дэвсгэр дээр хараар бичнэ.1000В хүртэл хүчдлийн цахилгааны тоолуурын нэгдсэн хайрцаг, тоног төхөөрөмжийн их бие тэдгээрийн хаалтууд дээр байрлуулах байнгын плакат юм.</p>	ш	285
28	<p>Хориглох плакат</p> 	<p>Дэвсгэрийн хэмжээ 200x160 мм, цагаан өнгөтэй, гадна хүрээ 5 мм өргөн, хар өнгөтэй, дээд талын 2/3-т 15 мм өргөн улаан дугуй дотор хар өнгийн сумтай, сумыг нь дайруулсан 450 налуу улаан зураастай байна. Доод хэсэгт “Бүү залга! Хүмүүс ажиллаж байна” гэж цагаан дэвсгэр дээр хараар бичнэ. Ажлын байранд хүчдэл өгч болзошгүй бүх таслах, залгах аппаратуудын залуур, дамжуулга дээр томыг нь, алсын удирдлагын түлхүүр, унтраалга, бариул, товлуур дээр жижгийг нь тавих зөөврийн плакат юм.</p>	ш	215
	<p>Хориглох плакат</p>	<p>Дэвсгэрийн хэмжээ 80x50 мм цагаан өнгөтэй, гадна хүрээ 5 мм өргөн, хар өнгөтэй, дээд талын 2/3-т 15 мм өргөн улаан</p>		

29	 <p>Бүү залга! Хүмүүс ажиллаж байна</p>	<p>дугуй дотор хар өнгийн сумтай, сумыг нь дайруулсан 450 налуу улаан зураастай байна. Доод хэсэгт “Бүү залга! Хүмүүс ажиллаж байна” гэж цагаан дэвсгэр дээр хараар бичнэ. Ажлын байранд хүчдэл өгч болзошгүй бүх таслах, залгах аппаратуудын залуур, дамжуулга дээр томыг нь, алсын удирдлагын түлхүүр, унтраалга, бариул, товлуур дээр жижгийг нь тавих зөөврийн плакат юм.</p>	ш	180
30	<p>Зөвшөөрөх плакат</p>  <p>Энд ажиллаж болно</p>	<p>Дэвсгэрийн хэмжээ 210x280 мм, цагаан өнгөтэй, гадна хүрээ 5 мм өргөн, хар өнгөтэй, дээд талын 2/3-т 190x190 мм ногоон өнгийн дэвсгэрдээр цагаан өнгийн сумтай байна. Доод хэсэгт “Энд ажиллаж болно” гэж хараар бичнэ. Ил хуваарилах байгууламж, дэд станцын ажил гүйцэтгэхээр бэлтгэсэн ажлын байр болон үйлдвэрийн доторх цахилгааны хуваарилах самбар, щит, кабель шугам, цахилгаан хөдөлгүүр гэх мэтийн тоног төхөөрөмж дээр ажил гүйцэтгэхээр бэлтгэсэн хэсэгт тавих зөөврийн плакат юм.</p>	ш	147
31	<p>Зөвшөөрөх плакат</p>  <p>Энд ажиллаж болно</p>	<p>Дэвсгэрийн хэмжээ 80x50 мм цагаан өнгөтэй, гадна хүрээ 5 мм өргөн, хар өнгөтэй, дээд талын 2/3-т 190x190 мм ногоон өнгийн дэвсгэрдээр цагаан өнгийн сумтай байна. Доод хэсэгт “Энд ажиллаж болно” гэж хараар бичнэ. Ил хуваарилах байгууламж, дэд станцын ажил гүйцэтгэхээр бэлтгэсэн ажлын байр болон үйлдвэрийн доторх цахилгааны хуваарилах самбар, щит, кабель шугам, цахилгаан хөдөлгүүр гэх мэтийн тоног төхөөрөмж дээр ажил гүйцэтгэхээр бэлтгэсэн хэсэгт тавих зөөврийн плакат юм.</p>	ш	148
32	<p>Заах плакат</p>  <p>Газардуулсан</p>	<p>Дэвсгэрийн хэмжээ 210x280 мм, цагаан өнгөтэй, гадна хүрээ 5 мм өргөн, хар өнгөтэй, дээд талын 2/3-т 190x190 мм хөх-цэнхэр өнгийн дэвсгэрдээр цагаан өнгийн сумтай байна. Доод хэсэгт “Газардуулсан” гэж хараар бичнэ.. Газардуулга тавьсан хэсэг рүү хүчдэл өгч болзошгүй бүх таслуур, залгуур, таслуур, рубильник, автомат зэргийн залуур, дамжуулгын бариул, түлхүүр, товчлуур дээр болон зөөврийн газардуулга тавьсан тавьсан</p>	ш	43

		буюу газардуулгын хутга залгасан цэгийн хаалга, хаалт, хашилт дээр тавих зөөврийн плакат юм.		
33	<p>Заах плакат</p> 	<p>Дэвсгэрийн хэмжээ 80x50 мм цагаан өнгөтэй, гадна хүрээ 5 мм өргөн, хар өнгөтэй, дээд талын 2/3-г 190x190 мм хөх-цэнхэр өнгийн дэвсгэрдээр цагаан өнгийн сумтай байна. Доод хэсэгт “Газардуулсан” гэж хараар бичнэ.</p> <p>Газардуулга тавьсан хэсэг рүү хүчдэл өгч болзошгүй бүх таслуур, залгуур, таслуур, рубильник, автомат зэргийн залуур, дамжуулгын бариул, түлхүүр, товчлуур дээр болон зөөврийн газардуулга тавьсан тавьсан буюу газардуулгын хутга залгасан цэгийн хаалга, хаалт, хашилт дээр тавих зөөврийн плакат юм</p>	ш	95

Стандарт: Монгол улсад мөрдөгдөж буй стандартыг хангасан байна.

1. Бараа хүргэх газар: **БЗӨБЦТС ТӨХК-ийн агуулахад**
2. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэм жих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
ХА 20/12	Цахилгаан хамгаалах хэрэгсэл нийлүүлэх тендер			БЗӨБЦТС ТӨХК-ийн агуулахад	14 хоног	21 хоног	

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

2019 оны дүгээр сарын-ны өдөр

БЗӨБЦТС ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Тавинбэх танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [тоо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
- 1.1. Захиалагчийн томилсон ажлын хэсэг бараа материалыг шалгаж, дүгнэлт үйлдэн хүлээн авна.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) Нийлүүлэх барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага:
Баталгаат засварын хугацаа **1 /нэг/** жил байна. Баталгаат хугацаанд илэрсэн доголдлыг талуудын төлөөлөгчид хамтран шалгаж актаар баталгаажуулах бөгөөд барааг нийлүүлэгч хуанлийн 10 хоногийн дотор өөрийн зардлаар сольж өгнө
- 4. Төлбөр (ГЕН – 7)**
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ.
Үүнд: Урьдчилгаа санхүүжилт олгохгүй. Гэрээний үнийн дүнгийн **100** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн гэрээний хэлцлийн хугацаанд барагдуулна.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹**
- 9.1. Алданги оногдуулах хувь: Хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн **0.5%**.
- Алдангийн нийт дүн: Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн **30%-с** ихгүй байна.
-

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ²

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № *[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]*

..... хот/аймаг

Нэг талаас *[захиалагчийн нэр]* (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас *[нийлүүлэгчийн нэр]* (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь *[гэрээний нэр, дугаар]*-г (цаашид “бараа” гэх) *[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]* (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____-наас _____ оны __ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх).
Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.
³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]